

**2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 14-НИЙ ӨДРИЙН ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ЗАСАГ ДАРГААС  
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Дүүргийн шуурхайн үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 03 дугаар сарын 22-ны “Лхагва” гарагт багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцно.

Биелэлтийг ирүүлэхдээ үүрэг даалгавар бүрийн хэрэгжилтийн хувийг тодорхой бичиж ирүүлнэ үү.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
<b>ИРГЭДИЙН ЭРҮҮЛ АЮУЛГҮЙ ОРЧИНД АМЬДРАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>		
1.	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх барилга байгууламжийн чанар, аюулгүй байдал, стандарт, өнөөгийн нөхцөл байдлын талаар “Барилгын чанар, аюулгүй байдал, стандарт” сэдэвт зөвлөгөөнийг 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулах бэлтгэл ажлыг сайтар хангаж, холбогдох мэргэжлийн байгууллагууд бодит мэдээлэл, судалгааг гаргаж, хамтран ажиллах.	ЗДТГ
2.	“Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үед төрийн байгууллагын харилцан хамтын ажиллагаа” сэдэвт Стратегийн команд штабын сургуулийн бэлтгэл ажлыг хангаж, идэвх санаачилгатай оролцох.	ОБХ, ААНБ-уудын удирдлагууд
3.	Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлын хүрээнд барилгын ажлын гаднах талбайн орчны аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавих нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайтар хангаж, хяналт тавьж ажиллах.	ТХҮХ
<b>УЛААНБААТАР ХОТЫН ЦАХИМ ШИЛЖИЛТИЙН ХҮРЭЭНД</b>		
4.	“Digital Ub” буюу Хэсгийн ахлагчийн аппликэйшнийг байгууллагуудын ажилтан, албан хаагчдаа танилцуулж хэрэглээг нэмэгдүүлж, цахимжуулах ажлаа эрчимжүүлэн, хэсгийн ахлагчдаас ирүүлсэн зөрчлийн талаарх мэдээ, мэдээллийг шуурхай шийдвэрлэн, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.	ЗДТГ, ТЗУХ, Хороод
5.	Замын хөдөлгөөний нэгдсэн систем /RFID/ буюу техникийн хяналтын цахим гэрчилгээг иргэдэд олгох, тээврийн хэрэгсэлд суурилуулах байршлуудаа судалж тодорхойлох, зохион байгуулалтын бэлтгэл ажлаа сайтар хангаж, мэргэжлийн чиг үүргийн байгууллагууд дэмжлэг үзүүлж ажиллах.	ЗДТГ
<b>ТӨСВИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД</b>		
6.	Дүүргүүд төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
7.	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд орчныхоо 50м хүртэлх талбайн өнгө үзэмжийг сэргээж, цэвэрлэгээг	Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон

	тогтмолжуулах, хайс хашааг угаах, хогны түүвэр цэвэрлэгээ хийх.	байгууламж ОНӨААТҮГ, ААНБ-ууд
8.	Тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтэд анхаарч шаардлагатай арга хэмжээг авч ажиллах.	Цагдаагийн хэлтэс
9.	Татварын орлого бүрдүүлэлтийн хүрээнд ААНБ-ууд өөрийн эзэмшилд байгаа тээврийн хэрэгслээ үзлэг оношлогоонд оруулахад бэлтгэх, ажилтан, албан хаагч, иргэдэд тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоонд орох талаар мэдээ, мэдээллийг хүргэж ажиллах.	Татварын хэлтэс, ААНБ-ууд, Хороод
10.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн зүгээс гэрэлтүүлгийн асалтыг 100%-д хүргэх чиглэл өгсний дагуу дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн асалтад анхаарч, засвар үйлчилгээг тогтмолжуулж ажиллах.	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
11.	Хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх (Он дамжин хийгдэж байгаа ажлууд, төсөв мөнгө нь тавигдсан ч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хугацаа хойшилсон ажлуудыг эхлүүлэхэд анхаарч бэлтгэлийг сайтар хангаж ажиллах)	СТСХ, ТХҮХ, ХААА
12.	Зүүн бүсийн боловсролын салбарын уулзалт 3 дугаар сард Багахангай дүүрэгт зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн тул арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг тодруулж, бэлтгэлийг хангаж ажиллах.	Боловсролын хэлтэс
13.	Батлагдан гарч буй захирамжуудын хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах.	ЗДТГ
14.	Урин дулааны улирал эхэлж байгаатай холбогдуулан нийтийн эзэмшлийн зам талбайн болон хүүхдийн тоглоомын талбайн эвдрэл гэмтэл, аюулгүй байдалд анхаарч эзэнгүй нохой, муур устгах ажлаа эрчимжүүлж ажиллах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ,